

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

2019.12.03

Улаанбаатар хот

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдүүд буюу үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компани, даатгагч болон даатгагчийн мэргэжлийн оролцогч, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч зэрэг нь тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна”, мөн зүйлийн 14.5-д ”Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье.

Хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах, нуун далдлах, хэлбэрийг өөрчлөх, хувиргах зорилгоор банк, санхүүгийн системд байршуулж, санхүүгийн олон төрлийн үйлчилгээ авч, эргэлдүүлэх замаар мөнгө угаах, мөн террорист үйл ажиллагаа, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх аюулыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ мөнгө угаах гэмт хэрэгт холбогдох, түүний золиос болох эрсдэлтэй нөхцөл үүсч болзошгүй юм.

Хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлд заасан торгуулийн арга хэмжээ авах болон Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл тус тус үүсэхийг анхааруулж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО